



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025-03-26 № 35-1/37
танай _____ -ны № _____ -т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ДАШЗЭГВИЙН
АМАРБАЯСГАЛАН ТАНАА


Г Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ





**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025. 03. 21 № XET/787
танай -ны № -т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.БААСАНДОРЖ ТАНАА

Г Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацаа товлох тухай

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалыг хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт 44 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.УЧРАЛ





МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025. 03. 18 № 1/1315
таний ны № ХЭГ/641 т

Г
МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА


Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.

О.АЛТАНГЭРЭЛ

A5.файл.2025

151801763

151600942



၁၆ ဧပြီ ၂၀၁၇ ခုနှစ်

၂၆ ဧပြီ ၂၀၁၇ ခုနှစ် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက်
၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက်

၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက်

၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက်

၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက်

၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက်

၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက်

၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက်

၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက်

၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက်

မြန်မာနိုင်ငြန် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက် ၁၁၁၅ ရက်



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025. 03. 13 № 1/1316
танай _____-ны № ХЭГ/642 т


МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай хуулийн төсөл болон дагалдуулан
боловсруулсан бусад хуулийн төсөл нь Хууль
тогтоомжийн тухай хуулийн 19¹.1 дүгээр зүйлийн 19¹.1 дэх
хэсэгт зааснаар Хууль тогтоомжийн тухай хуульд заасан
шаардлагыг хангасан байна.



A5.файл.2025

151601270



151600341

କଥି ରାଜ୍ୟମାନ / ଶୁଣିବାକାହୀରେ ଏବଂ ବିଲିମିଳିମାନ / ତଣ୍ଡାରୁ ..
 ଲାଗୁ ହବି ରାଜ୍ୟମାନ / ଲାଗୁ ବିଜେତା ବିଜେତାରୁ ଏବଂ ବିଜେତା ବିଜେତା
 ବିଜେତାରୁ ଏବଂ ବିଜେତା ଏବଂ ୧୯୭୫ ଫରିଦ ଚନ୍ଦ୍ର ଏବଂ ୧୯୭୫ ଫରିଦ
 ବିଜେତାରୁ ଏବଂ ବିଜେତା ଏବଂ ୧୯୭୫ ଫରିଦ ଚନ୍ଦ୍ର ଏବଂ ୧୯୭୫ ଫରିଦ
 ବିଜେତାରୁ ଏବଂ ବିଜେତା ଏବଂ ୧୯୭୫ ଫରିଦ ଚନ୍ଦ୍ର ଏବଂ ୧୯୭୫ ଫରିଦ

ଶ୍ରୀ ମହାତ୍ମା ଗାଁର
ନାମ କରିଲେ ଫିରାନ୍ତି ଏବଂ ପାଞ୍ଚମି
ପରିବାର କରିଲୁ ଏବଂ ପାଞ୍ଚମି ଏବଂ

ବ୍ୟାକ୍ ବ୍ୟାକ୍ ବ୍ୟାକ୍ ବ୍ୟାକ୍ ବ୍ୟାକ୍ ବ୍ୟାକ୍ ବ୍ୟାକ୍

ਜਾਰੀ ਕੀਤਾ ਗਿਆ ਹੈ : www.mojha.gov.mn
 ਜਾਰੀ ਕੀਤਾ ਗਿਆ ਹੈ : info@mojha.gov.mn •
 ਫ਼ੋਨ : (976-51) 26 75 33 • ਫ਼ੋਨ : (976) 26 75 33 •
 ਪ੍ਰਾਪਤੀ ਅਧਿਕਾਰੀ • ਇੰਡੋਨੇਸ਼ਨਾਲ ਮੈਂਬਰ • 15160
 ਸਾਲ ਵਿੱਚ ਮਿਲੀ ਵਿੱਚ 5 ਛਾਪਾਂ ਮਿਲੀ + ਮਿਲੀ ਮਿਲੀ ਵਿੱਚ 8/4 •

ଶାକବିହାର ପାଇଁ କାହାର କାହାର
କାହାର କାହାର କାହାର କାହାର ?



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзандийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2025. 03. 10 № 01/1596

танай 2025. 03. 10 ны № ХЭГ/641-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761000495

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭС**

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“5.ХЭЛЭЛЦСЭН нь: Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРАА

Н.УЧРАЛ



МОНГОЛ УЛСЫН
ТЭРГҮҮН ШАДАР САЙД
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД

Л.ГАНТОМОР




САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

О.АЛТАНГЭРЭЛ



ЦАХИМ ХӨГЖИЛ,
ИННОВАЦ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙД

Ц.БААТАРХҮҮ

ATA12939 6806252 9024070591

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж, Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “...үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.” гэж тус тус заасан.

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.4 дэх заалтад зааснаар төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх бөгөөд тусгай зөвшөөрлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгохоор тусгасан.

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 3-т “Хуулиар зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааг эрхлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг тухайлсан хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.” гэж заасан бөгөөд эдгээр үйл ажиллагаа болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой эрх, үүрэг, шаардлагыг нарийвчлан зохицуулсан зохицуулалт одоогоор байхгүй байна.

Харин Монгол Улсад Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай 1999 оны нэг зүйлтэй хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар мөрийтэй тоглоом тоглох, зохион байгуулахыг хориглож, хүлээлгэх хариуцлагыг тогтоосон.

1.2.Практик шаардлага

Үндэсний статистикийн хорооноос хийсэн судалгаагаар 2023 оны байдлаар эдийн засгийн гэмт хэрэг 200 бүртгэгдсэн ба 2024 онд Монгол Улсад эдийн засгийн гэмт хэргийн улмаас нийт 417.2 тэрбум төгрөгийн хохирол учирч, эдийн засгийн гэмт хэргийн хохирогчийн 9.2 хувийг 18-29 насын бүлэг, 47.7 хувийг 30-39 насын бүлэг, 24.6 хувийг 40-49 насын бүлэг эзэлж байна. Мөрдөн шалгах ажиллагааны явцад 240.9 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 23.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт цахим болон цахим бус хэлбэрээр хууль бусаар мөрийтэй болон бооцоот тоглоомын үйл ажиллагаа явуулах замаар мөнгө угаах, бусдыг залилах, татвар төлөхөөс зайлсхийх зэргээр эдийн засгийн гэмт хэргүүд ихээр үйлдэгдэж, сүүлийн 3 жилийн хугацаанд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.17 дугаар зүйлд заасан Мөрийтэй тоглоом зохион байгуулах зүйл ангиар 669 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж 200 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай явуулж, 104 хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн байна. Монгол улсад давхардсан тоогоор сүүлийн 3 жилийн хугацаанд хууль бус мөрийтэй тоглоомын 350-450 орчим сайт үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж байна.

Цахимаар мөрийтэй тоглоом болон бусад төрлийн бооцоот тоглоом эрхэлдэг гадаадын хуулийн этгээдийн үйл ажиллагаа Монгол Улсын хүн амын дунд түгээмэл болсон байгаа нь зайлшгүй шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудал болоод байна. Цагдаагийн байгууллагаас цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн дуудлага, мэдээлэлд хойшлуулшгүй ажиллагаа явуулж, арилжааны банкуудтай хамтран 2024 онд бусдад учирсан 7,3 тэрбум төгрөгийн хохиролтой 1,318 дуудлага, мэдээлэлд нийт мөнгөн дүнгийн 71,2 хувь буюу 5,2 тэрбум төгрөгийн дансны гүйлгээний шилжилт хөдөлгөөнд хязгаарлалт тогтоож, 120 иргэний 2,1 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, болзошгүй эрсдэлээс хамгаалсан.

Харин учирсан нийт хохирлын 28,8 хувь буюу 2,1 тэрбум төгрөгийн хохиролтой 565 дуудлага, мэдээлэлд хязгаарлалт тогтоогоогүй бөгөөд үүний үндсэн шалтгаан нь 18,2 хувь буюу 103 иргэнээс хугацаа алдаж дуудлага ирүүлсэн, 47,9 хувь буюу 271 сэжигтэй этгээд ATM /бэлэн мөнгөний машин/ ашиглан бэлнээр авсан, 33,8 хувь буюу 191 сэжигтэй этгээд арилжааны хэд хэдэн банкны данс шилжүүлэн Binance, 1XBET зэрэгт мөнгөн гүйлгээ хийх замаар мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдсэнийг шалгаж байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос цахим хэлбэрээр үйлдэгдсэн хууль бус мөрийтэй тоглоомыг таслан зогсоох зорилгоор 2022-2024 онд Монгол улсын ерөнхий прокурорын газар, Монголбанк, Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн алба болон Харилцаа холбооны зохицуулах хорооны хамтарсан “Хяналт-1” болон “Хяналт-2” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан. Уг арга хэмжээний хүрээнд нийт цахимаар хууль бус мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа явуулсан 6036 домэйн хаягийн Монгол Улсаас хандах хандалтыг хязгаарласан байна.

2024 онд цахим мөрийтэй тоглоомтой холбоотой цагдаагийн байгууллагаас ирүүлсэн албан бичгийн дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооноос хүсэлтийг META компанид хүргүүлж, дараах байдлаар шийдвэрлэж ажилласан байна:

№	Байгууллага	Зөрчил	Ирүүлсэн албан бичиг	Линк	Шийдвэрлэгдсэн	Хувь

1	Цагдаа	Мөрийтэй тоглоом /META/	276	2456	1876	76.38%
---	--------	-------------------------	-----	------	------	--------

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.4 дэх заалтад заасан төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг “Темп партнерс” ХХК, “Эн Зэт Жи Эм” ХХК, “Мон Экс Бэй Ти Билэг” ХХК-д олгож, олон улсад бооцоот тоглоомын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 1XBET сайт нь одоогоор тусгай зөвшөөрөлгүй байна.

Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн мэдээллээр Монгол Улсын нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхэлж байгаа спортын бооцоот тоглоомын 1XBET сайтаар дамжуулан гэмт хэргийн замаар олсон хууль бус хөрөнгийг гүйвуулах, нуун далдлах, оффшор эргэлтэд оруулах, мөнгө угаах гол хэрэгсэл болж, бусдын эд хөрөнгийг залилах, хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээг далд байдлаар дэмжих, мөрийтэй тоглоом тоглох, авлига, албан тушаалын гэмт хэргийн замаар олсон мөнгийг угааж байгаа нөхцөл байдал тогтоогдсон.

Мөн мөрийтэй тоглоом тоглогчдод мөнгөн шилжүүлгийн үйлчилгээ үзүүлж, пирамид хэлбэрээр салбарлаж, бүлгийн зохион байгуулалттайгаар 1XBET-тэй гэрээ байгуулан цалин авч, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 110 гаруй “агент” байна гэсэн тоон мэдээ гарсан бөгөөд цагдаагийн байгууллагаас Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг үндэслэн Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албатай хамтран агентийн үйл ажиллагаа эрхэлдэг арилжааны банкууд дахь дансны гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг түдгэлзүүлэн шалгалтын ажиллагаа явуулсан байна. Энэ явцад их хэмжээний ашиг орлого олсон 11 агентад холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.3 дугаар зүйл (Татвар төлөхөөс зайлсхийх), 18.6 дугаар зүйл (Мөнгө угаах)-ийн хүрээнд 11 хэрэг бүртгэлтийн хэрэг нээн Нийслэлийн прокурорын газрын хяналтанд мөрдөн шалгах ажиллагаа явуулж, Татварын ерөнхий газартай хамтран 112 агентад татварын хяналт шалгалт хийж ажиллахад 23 танилцуулга гарч, 24 акт тавьж, 65 агентад шалгалт хийгдэж байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд зааснаар Төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны хонжворын орлогод 40 хувиар татвар ногдуулахаар, мөн Онцгой албан татварын тухай хуулийн 4.2-т зааснаар Төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тусгай зориулалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн биет нэгж, тус үйл ажиллагааг эрхлэн явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дараах хэмжээгээр онцгой албан татвар ногдуулахаар тус тус заасан:

Д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Биет нэгжид ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр, сард/
1	Тоглоомын ширээ буюу электрон хүрд	116000000
2	Автомат тоглоом	4350000
3	Тоглоомын үр дүнг харуулсан касс буюу тотализатор	116000000
4	Бооцоо тооцоолох букмейкерийн төв	116000000

Мөн дээрх хуульд зааснаар төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагааг цахим, интернэт, үүрэн телефоны сүлжээ ашиглан эрхэлж байгаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд сар тутам 36250000 төгрөгтэй тэнцэх хэмжээгээр онцгой албан татвар ногдуулахаар зохицуулалттай хэдий ч дээрх хуулийн зохицуулалтын хүрээнд улсын төсөвт ямар нэгэн татвар төлөгдөөгүй байна.

Монополын эсрэг газраас цагдаагийн байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран Монгол Улсын нутаг дэвсгэрт төлбөрт таавар, бооцоот тоглоомын зар сурталчилгааг бүтээж, түгээж байгаа этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, Зар сурталчилгааны тухай хуулийн 6.5.1-д “зөвшөөрөл аваагүй тохиолдолд тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааны талаар аливаа зар сурталчилгаа явуулахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн нэр бүхий 2 аж ахуй нэгж, 7 контент бүтээгчийн зөрчлийн шинжтэй үйлдэлд Зөрчлийн тухай хуулийн 10.1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтад заасны дагуу нийт 13.500.000 төгрөгийн торгууль ногдуулсан.

Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны явцад Арабын Нэгдсэн Эмират, Хонг Конг зэрэг улсуудад бүртгэлтэй хуулийн этгээдээр дамжуулан Монгол улсад бүртгэлтэй нэр бүхий аж ахуй нэгжтэй 6.000-77.000 доллар хүртэлх гэрээ байгуулж спортын бооцоот тоглоомын 1XBET-ээс манай улсруу зар сурталчилгааны зорилгоор 3,345,468,075 төгрөг буюу 976,779 ам.доллар шилжүүлсэн боловч манай улсаас 1.7 их наяд төгрөг буюу 500 сая ам.доллар агентуудаар дамжин гадагш гарсан байна. Энэ нь гадаад улсын вэбсайтуудаар Монгол Улсын иргэд цахим гэмт хэрэг, залилангийн хохирогч болж, хөрөнгөө их хэмжээгээр алдах эрсдэлийг дагуулж, үндэсний валют хяналтгүйгээр гадагш урсаж, манай улсын эдийн засагт ихээхэн хохирол учруулж байгаа тул эдийн засгийн аюулгүй байдлыг хангах шаардлагатай байна.

Data40.com байгууллагаас хийсэн судалгаагаар (www.data40.com) гадаад улс орнуудын цахим мөрийтэй болон бооцоот тоглоомыг хүлээн зөвшөөрч байгаа эсэх талаар 2024 оны 09 дүгээр сард гаргасан жагсаалтад манай улстай нийгмийн үнэлэмж, соёл, уламжлалын хувьд ижил төсөөтэй Ази-Номхон далайн бус нутгийн улс орнуудыг судалж үзэхэд, нийт 46 улс орны 21 улс нь цахим мөрийтэй болон бооцоот тоглоомыг хууль бус гэж тооцож, 7 улс хуулиар хүлээн зөвшөөрч, 6 улс хэсэгчилсэн байдлаар зохицуулж, 13 улс одоогоор зохицуулалтгүй байна. Хууль бус гэж тооцсон улс орны тоонд Япон, БНСУ, БНХАУ, Тайланд (морин уралдаанаас бусад), Вьетнам, Индонез, Малдив, Непал, Лаос, Бангладеш зэрэг улс орныг дурдаж болно. Мөн мөрийтэй болон бооцоот тоглоомын газар ажиллуулахыг хууль бус гэж тооцсон 18, хүлээн зөвшөөрсөн 15, хэсэгчилсэн 8, зохицуулалтгүй 4, зөвхөн засгийн газар нь зохицуулдаг 1 улс байна. Япон, БНСУ, Сингапур зэрэг улс орнууд уламжлалт мөрийтэй тоглоомын зарим хэлбэрийг хүлээн зөвшөөрдөг байна. Харин хуулиараа мөрийтэй болон бооцоот тоглоомыг хууль бус гэж тооцдог улсын орнуудын тоонд Индонез Улс ордог зэрэг олон улсын туршлагыг дурдаж болно.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зорилго нь Монгол Улсын иргэд цахим гэмт хэрэг, мөрийтэй болон бооцоот тоглоом, залилангийн хохирогч болж, хөрөнгөө их хэмжээгээр алдах эрсдэлээс урьдчилан

сэргийлэх, гадагш чиглэсэн үндэсний валютын хяналтгүй урсгалыг зогсоож эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад оршино.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу боловсруулна. Хуулийн төсөл нь З зүйлтэй байх бөгөөд 1 дүгээр зүйлд хуулийн төсөлд төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэхийг хориглож, 2 дугаар зүйлд Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт заасны дагуу хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс олгодог төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагаанаас хасахаар, 3 дугаар зүйлд хууль хүчин төгөлдөр болох талаар тусгана.

Хуулийн төслийг дагаж Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхэлсэн, төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомд зуучилсан үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор тусгана. Мөн төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэх гэмт хэргийг үйлдэж бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж, эсхүл зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр тусгана.

Түүнчлэн төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэхэд өөрийн нэр дээр бүртгэлтэй төлбөр тооцооны данс, цахим мөнгө, виртуал хөрөнгө, харилцаа холбооны сүлжээний дугаар, цахим хаягаа бусдад ашиглуулсан тохиолдолд Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэхээр заана.

Мөн Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, төлбөрт таавар, бооцоот тоглоом, мөрийтэй тоглоомыг сурталчилж, уриалахыг хориглож, хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тусгана.

Мөрийтэй болон бооцоот тоглоомоос олсон хууль бус хөрөнгийг гүйвуулах, нуун далдлах, оффшор эргэлтэд оруулах, мөнгө угаах нөхцөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Банкны тухай хуульд нэмэлт оруулж, төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэх, зуучлах, төлбөрт таавар, бооцоот тоглоом, мөрийтэй тоглоом сурталчлах, эсхүл цахим хэрэгслийг ашигласан залилах гэмт хэрэгтэй тэмцэхэд шаардлагатай мэдээллийг хуульд заасны дагуу мөрдөн шалгах байгууллагаас шаардсан тохиолдолд гаргаж өгөх талаар тусгана.

Мөн Зөвшөөрлийн тухай хуульд төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэхийг хориглохоор заасантай холбогдуулан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Онцгой албан татварын тухай, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Зөвшөөрлийн тухай хууль болон түүнийг дагаж холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар дараах үр дагавар гарна гэж үзэж байна:

-Манай улсын эдийн засагт ихээхэн хэмжээний хохирол учруулж, эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байгаа үйлдлийг таслан зогсоох, хүүхэд, залуучуудын мөрийтэй болон бооцоот тоглоом тоглож, сэтгэл зүйн хувьд донтох, эрүүл мэнд, амь насанд учрах эрсдэлээс сэргийлнэ;

-Төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхэлсэн, зуучилсан болон төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэхэд өөрийн нэр дээр бүртгэлтэй төлбөр тооцооны данс, цахим мөнгө, виртуал хөрөнгө, харилцаа холбооны сүлжээний дугаар, цахим хаягаа бусдад ашиглуулсан этгээдийн үйлдлийг гэмт хэрэгт тооцож хариуцлага хүлээлгэн, Монгол Улсын иргэд цахим гэмт хэрэг, залилангийн хохирогч болж, хөрөнгөө их хэмжээгээр алдах эрсдэлээс урьдчилан сэргийлнэ;

-Зар сурталчилгааны тухай хуулиар төлбөрт таавар, бооцоот тоглоом, мөрийтэй тоглоом тоглохыг сурталчлахыг хориглоогүй, хүлээлгэх хариуцлага тодорхойгүй байгаатай холбогдуулан зохицуулалтыг холбогдох хуульд тусгаж, сурталчилсан этгээдэд хариуцлага тооцох, төлбөрт таавар, бооцоот тоглоом, мөрийтэй тоглоомыг сурталчлах нь хэвийн мэтээр хэвшсэн ойлголтыг өөрчилж, хүүхэд, залуучуудыг бооцоот тоглоом, мөрийтэй тоглоомд уриалан дуудаж байгаа хууль бус сурталчилгаануудыг хязгаарлаж, таслан зогсоно.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төслийг дагаж Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

ТАНИЛЦУУЛГА

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн
төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад
хуулийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж, Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “...үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.” гэж тус тус заасан.

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.4 дэх заалтад зааснаар төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх бөгөөд тусгай зөвшөөрлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгохоор тусгасан.

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 3-т “Хуулиар зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааг эрхлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг тухайлсан хуулиар зохицуулснаас бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой эрх, үүрэг, шаардлагыг нарийвчлан зохицуулсал зохицуулалт одоогоор байхгүй байна.

Харин Монгол Улсад Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай 1999 оны нэг зүйлтэй хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар мөрийтэй тоглоом тоглох, зохион байгуулахыг хориглож, хүлээлгэх хариуцлагыг тогтоосон.

Үндэсний статистикийн хорооноос хийсэн судалгаагаар 2023 оны байдлаар эдийн засгийн гэмт хэрэг 200 бүртгэгдэж, 2024 онд эдийн засгийн гэмт хэргийн улмаас нийт 417.2 тэрбум төгрөгийн хохирол учирч, эдийн засгийн гэмт хэргийн хохирогчийн 9.2 хувийг 18-29 насны бүлэг, 47.7 хувийг 30-39 насны бүлэг, 24.6 хувийг 40-49 насны бүлэг эзэлж байна. Мөрдөн шалгах ажиллагааны явцад 240.9 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 23.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт цахим болон цахим бус хэлбэрээр хууль бусаар мөрийтэй болон бооцоот тоглоомын үйл ажиллагаа явуулах замаар мөнгө угаах, ихээр үйлдэгдэж, сүүлийн 3 жилийн хугацаанд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.17 дугаар зүйлд заасан Мөрийтэй тоглоом зохион байгуулах зүйл ангиар 669 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж 200 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай явуулж, 104 хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн байна. Монгол улсад давхардсан тоогоор сүүлийн 3 жилийн хугацаанд хууль бус мөрийтэй тоглоомын 350-450 орчим сайт үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж байна.

Цахимаар мөрийтэй тоглоом болон бусад төрлийн бооцоот тоглоом эрхэлдэг гадаадын хуулийн этгээдийн үйл ажиллагаа Монгол Улсын хүн амын дунд түгээмэл

болсон байгаа нь зайлшгүй шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудал болоод байна. Цагдаагийн байгууллагаас цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн дуудлага, мэдээлэлд хойшлуулшгүй ажиллагаа явуулж, арилжааны банкуудтай хамтран 2024 онд бусдад учирсан 7,3 тэрбум төгрөгийн хохиролтой 1,318 дуудлага, мэдээлэлд нийт мөнгөн дүнгийн 71,2 хувь буюу 5,2 тэрбум төгрөгийн дансны гүйлгээний шилжилт хөдөлгөөнд хязгаарлалт тогтоож, 120 иргэний 2,1 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, болзошгүй эрсдэлээс хамгаалсан.

Харин учирсан нийт хохирлын 28,8 хувь буюу 2,1 тэрбум төгрөгийн хохиролтой 565 дуудлага, мэдээлэлд хязгаарлалт тогтоогоогүй бөгөөд үүний үндсэн шалтгаан нь 18,2 хувь буюу 103 иргэнээс хугацаа алдаж дуудлага ирүүлсэн, 47,9 хувь буюу 271 сэжигтэй этгээд ATM /бэлэн мөнгөний машин/ ашиглан бэлнээр авсан, 33,8 хувь буюу 191 сэжигтэй этгээд арилжааны хэд хэдэн банкны данс шилжүүлэн Binance, 1XBET зэрэгт мөнгөн гүйлгээ хийх замаар мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдсэнийг шалгаж байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос цахим хэлбэрээр үйлдэгдсэн хууль бус мөрийтэй тоглоомыг таслан зогсоох зорилгоор 2022-2024 онд Монгол улсын ерөнхий прокурорын газар, Монголбанк, Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн алба болон Харилцаа холбооны зохицуулах хорооны хамтарсан “Хяналт-1” болон “Хяналт-2” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан. Уг арга хэмжээний хүрээнд нийт цахимаар хууль бус мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа явуулсан 6036 домэйн хаягийн Монгол Улсаас хандах хандалтыг хязгаарласан байна.

2024 онд цахим мөрийтэй тоглоомтой холбоотой цагдаагийн байгууллагаас ирүүлсэн албан бичгийн дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооноос хүсэлтийг META компанид хүргүүлж, дараах байдлаар шийдвэрлэж ажилласан байна:

№	Байгууллага	Зөрчил	Ирүүлсэн албан бичиг	Линк	Шийдвэрлэгдсэн	Хувь
1	Цагдаа	Мөрийтэй тоглоом /META/	276	2456	1876	76.38%

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.4 дэх заалтад заасан төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг “Темп партнерс” ХХК, “Эн Зэт Жи Эм” ХХК, “Мон Экс Бэй Ти Билэг” ХХК-д олгож, олон улсад бооцоот тоглоомын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 1XBET сайт нь одоогоор тусгай зөвшөөрөлгүй байна.

Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн мэдээллээр Монгол Улсын нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхэлж байгаа спортын бооцоот тоглоомын 1XBET сайтаар дамжуулан гэмт хэргийн замаар олсон хууль бус хөрөнгийг гүйвуулах, нуун далдлах, оффшор эргэлтэд оруулах, мөнгө угаах гол хэрэгсэл болж, бусдын эд хөрөнгийг залилах, хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээг далд байдлаар дэмжих, мөрийтэй тоглоом тоглох, авлига, албан тушаалын гэмт хэргийн замаар олсон мөнгийг угааж байгаа нөхцөл байдал тогтоогдсон.

Мөн мөрийтэй тоглоом тоглогчдод мөнгөн шилжүүлгийн үйлчилгээ үзүүлж, пирамид хэлбэрээр салбарлаж, бүлгийн зохион байгуулалттайгаар 1XBET-тэй гэрээ байгуулан цалин авч, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 110 гаруй "агент" байна гэсэн тоон мэдээ гарсан бөгөөд цагдаагийн байгууллагаас Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг үндэслэн Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албатай хамтран агентийн үйл ажиллагаа эрхэлдэг арилжааны банкууд дахь дансны гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг түдгэлзүүлэн шалгалтын ажиллагаа явуулсан байна. Энэ явцад их хэмжээний ашиг орлого олсон **11** агентад холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.3 дугаар зүйл (Татвар төлөхөөс зайлсхийх), 18.6 дугаар зүйл (Мөнгө угаах)-ийн хүрээнд **11** хэрэг бүртгэлтийн хэрэг нээн Нийслэлийн прокурорын газрын хяналтанд мөрдөн шалгах ажиллагаа явуулж, Татварын ерөнхий газартай хамтран **112** агентад татварын хяналт шалгалт хийж ажиллахад **23** танилцуулга гарч, **24** акт тавьж, **65** агентад шалгалт хийгдэж байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд зааснаар Төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны хонжворын орлогод 40 хувиар татвар ногдуулахаар, мөн Онцгой албан татварын тухай хуулийн 4.2-т зааснаар Төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тусгай зориулалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн биет нэгж, тус үйл ажиллагааг эрхлэн явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дараах хэмжээгээр онцгой албан татвар ногдуулахаар тус тус заасан:

Д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Биет нэгжид ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр, сард/
1	Тоглоомын ширээ буюу электрон хүрд	116000000
2	Автомат тоглоом	4350000
3	Тоглоомын үр дүнг харуулсан касс буюу тотализатор	116000000
4	Бооцоо тооцоолох букмейкерийн төв	116000000

Мөн дээрх хуульд зааснаар төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагааг цахим, интернэт, үүрэн телефоны сүлжээ ашиглан эрхэлж байгаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд сар тутам 36250000 төгрөгтэй тэнцэх хэмжээгээр онцгой албан татвар ногдуулахаар зохицуулалттай хэдий ч дээрх хуулийн зохицуулалтын хүрээнд улсын төсөвт ямар нэгэн татвар төлөгдөөгүй байна.

Монополын эсрэг газраас цагдаагийн байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран Монгол Улсын нутаг дэвсгэрт төлбөрт таавар, бооцоот тоглоомын зар сурталчилгааг бүтээж, түгээж байгаа этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, Зар сурталчилгааны тухай хуулийн 6.5.1-д "зөвшөөрөл аваагүй тохиолдолд тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааны талаар аливаа зар сурталчилгаа явуулахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн нэр бүхий 2 аж ахуй нэгж, 7 контент бүтээгчийн зөрчлийн шинжтэй үйлдэлд Зерчлийн тухай хуулийн 10.1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтад заасны дагуу нийт 13.500.000 төгрөгийн торгууль ногдуулсан.

Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны явцад Арабын Нэгдсэн Эмират, Хонг Конг зэрэг улсуудад бүртгэлтэй хуулийн этгээдээр дамжуулан Монгол улсад бүртгэлтэй нэр бүхий аж ахуй нэгжтэй 6.000-77.000 доллар хүртэлх гэрээ байгуулж спортын бооцоот тоглоомын 1XBET-ээс манай улсрнуу зар сурталчилгааны зорилгоор 3,345,468,075 төгрөг буюу 976,779 ам.доллар шилжүүлсэн боловч манай улсаас 1.7 их наяд төгрөг буюу 500 сая ам.доллар агентуудаар дамжин гадагш гарсан байна. Энэ нь гадаад улсын вэбсайтуудаар Монгол Улсын иргэд цахим гэмт хэрэг, залилангийн хохирогч болж, хөрөнгөө их хэмжээгээр алдах эрсдэлийг дагуулж, үндэсний валют хяналтгүйгээр гадагш урсаж, манай улсын эдийн засагт ихээхэн хохирол учруулж байгаа тул эдийн засгийн аюулгүй байдлыг хангах шаардлагатай байна.

Data40.com байгууллагаас хийсэн судалгаагаар (www.data40.com) гадаад улс орнуудын цахим мөрийтэй болон бооцоот тоглоомыг хүлээн зөвшөөрч байгаа эсэх талаар 2024 оны 09 дүгээр сард гаргасан жагсаалтад манай улстай нийгмийн үнэлэмж, соёл, уламжлалын хувьд ижил төсөөтэй Ази-Номхон далайн бус нутгийн улс орнуудыг судалж үзэхэд, нийт 46 улс орны 21 улс нь цахим мөрийтэй болон бооцоот тоглоомыг хууль бус гэж тооцож, 7 улс хуулиар хүлээн зөвшөөрч, 6 улс хэсэгчилсэн байдлаар зохицуулж, 13 улс одоогоор зохицуулалтгүй байна. Хууль бус гэж тооцсон улс орны тоонд Япон, БНСУ, БНХАУ, Тайланд (морин уралдаанаас бусад), Вьетнам, Индонез, Малдив, Непал, Лаос, Бангладеш зэрэг улс орныг дурдаж болно. Мөн мөрийтэй тоглоомын газар ажиллуулахыг хууль бус гэж тооцсон 18, хүлээн зөвшөөрсөн 15, хэсэгчилсэн 8, зохицуулалтгүй 4, зөвхөн Засгийн газар нь зохицуулдаг 1 улс байна. Япон, БНСУ, Сингапур зэрэг улс орнууд уламжлалт мөрийтэй тоглоомын зарим хэлбэрийг хүлээн зөвшөөрдөг байна. Харин хуулиараа мөрийтэй болон бооцоот тоглоомыг хууль бус гэж тооцдог улсын орнуудын тоонд Индонез Улс ордог зэрэг олон улсын туршлагыг дурдаж болно.

Иймд манай улсын эдийн засагт ихээхэн хэмжээний хохирол учруулж, эдийн засгийн аюулгүй байдалд сэргээр нэлөөлж байгаа үйлдлийг таслан зогсоох зорилгоор Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу боловсруулж, хуулийн төсөлд төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэхийг хориглож, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт заасны дагуу хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс олгодог төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагаанаас хасахаар тусгалаа.

Хуулийн төслийг дагаж Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхэлсэн, төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомд зуучилсан үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор тусгалаа. Мөн төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэх гэмт хэргийг үйлдэж бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж, эсхүл зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан болно.

Түүнчлэн төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэхэд өөрийн нэр дээр бүртгэлтэй төлбөр тооцооны данс, цахим

мөнгө, виртуал хөрөнгө, харилцаа холбооны сүлжээний дугаар, цахим хаягаа бусдад ашиглуулсан тохиолдолд Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэхээр нэмж тусгасан.

Мөн Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, төлбөрт таавар, бооцоот тоглоом, мөрийтэй тоглоомыг сурталчилж, уриалахыг хориглож, хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тусгалаа.

Мөрийтэй болон бооцоот тоглоомоос олсон хууль бус хөрөнгийг гүйвуулах, нуун далдлах, оффшор эргэлтэд оруулах, мөнгө угаах нөхцөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Банкны тухай хуульд нэмэлт оруулж, төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэх, зуучлах, төлбөрт таавар, бооцоот тоглоом, мөрийтэй тоглоом сурталчлах, эсхүл цахим хэрэгслийг ашигласан залиах гэмт хэрэгтэй тэмцэхэд шаардлагатай мэдээллийг хуульд заасны дагуу мөрдөн шалгах байгууллагаас шаардсан тохиолдолд гаргаж өгөх талаар тусгалаа.

Мөн Зөвшөөрлийн тухай хуульд төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэхийг хориглохоор заасантай холбогдуулан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Онцгой албан татварын тухай, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

---00---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн
төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад
хуулийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж, Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “...үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.” гэж тус тус заасан.

Төлбөрт таавар, бооцоот тоглоом, мөрийтэй тоглоомын талаарх Монгол Улсын хууль эрх зүйн орчин:

Монгол Улсын хувьд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2003 оны 155 дугаар тушаалаар “Төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа явуулах журам”-ыг баталж байсан бөгөөд уг журмыг 2008 онд хүчингүй болгосон байна. Мөн 2022 онд Улсын Их Хурлын нэр бүхий гишүүд Казиногийн тухай хуулийн төслийг Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хууль нэртэйгээр санаачлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн боловч дэмжигдээгүй. Уг хуулийн төслөөр Монгол Улсын нутаг дэвсгэрт мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэх нийтлэг зохицуулалтыг бий болгох, бооцоот таавар, хонжворт сугалааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, оролцогчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулна гэж тодорхойлсон байна. Одоогийн байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн актуудад тус зах зээлийн талаар дараах зохицуулалтууд байна. Үүнд:

1. Зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр бүлгийн 11.4 дэх заалтад “төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгох”-оор, мөн зүйлийн 6.5-д “эд мөнгөний хонжворт сугалаа гаргах тусгай зөвшөөрлийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгох”-оор тус тус заасан. Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 3-т “Хуулиар зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааг эрхлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг

тухайлсан хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна." гэж заасан бөгөөд эдгээр үйл ажиллагаа болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой эрх, үүрэг, шаардлагыг нарийвчлан зохицуулсан зохицуулалт одоогоор байхгүй байна.

2.Монгол Улсад Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай 1999 оны нэг зүйлтэй хууль хүчин төгөлдөр үйлчилж байна.

3.Эрүүгийн хуулийн 20.17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Олон нийтийн газар, эсхүл мэдээллийн технологи ашиглан ашиг олох зорилгоор шоо, хөзөр, бусад эд зүйл ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог мөрийтэй тоглоом зохион байгуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ." гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог хуулиар хориглосон мөрийтэй тоглоомын газар байгуулсан, эсхүл ажиллуулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ." гэж тус тус мөрийтэй тоглоом зохион байгуулахад хүлээлгэх хариуцлагыг зохицуулалтыг тусгасан.

4.Зөрчлийн тухай хуулийн 5.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Олон нийтийн газар ашиг олох зорилгоор мөрийтэй тоглоом тоглосон бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг 100 нэгж буюу нэг зуун мянган төгрөгөөр торгоно." гэж заасан.

5.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд зааснаар Төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны хонжворын орлогод 40 хувиар татвар ногдуулахаар заасан. Онцгой албан татварын тухай хуулийн 4.2-т зааснаар Төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тусгай зориулалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн биет нэгж, тус үйл ажиллагааг эрхлэн явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дараах хэмжээгээр онцгой албан татвар ногдуулахаар заасан:

Д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Биет нэгжид ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр, сард/
1	Тоглоомын ширээ буюу электрон хүрд	116000000
2	Автомат тоглоом	4350000
3	Тоглоомын үр дүнг харуулсан касс буюу тотализатор	116000000
4	Бооцоо тооцоолох букмейкериийн төв	116000000

Мөн дээрх хуульд зааснаар төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагааг цахим, интернэт, үүрэн телефоны сүлжээ ашиглан эрхэлж байгаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд сар тутам 36250000 төгрөгтэй тэнцэх хэмжээгээр онцгой албан татвар ногдуулахаар заасан хэдий ч Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд зааснаар Төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны хонжворын орлогод 40 хувиар татвар ногдуулахаар, мөн Онцгой албан татварын тухай хуулийн 4.2-т зааснаар Төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тусгай зориулалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн биет нэгж, тус үйл ажиллагааг эрхлэн явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дараах хэмжээгээр онцгой албан татвар ногдуулахаар тус тус заасан:

Д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Биет нэгжид ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр, сард/
1	Тоглоомын ширээ буюу электрон хүрд	116000000
2	Автомат тоглоом	4350000
3	Тоглоомын үр дүнг харуулсан касс буюу тотализатор	116000000
4	Бооцоо тооцоолох букмейкериийн төв	116000000

Мөн дээрх хуульд зааснаар төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагааг цахим, интернэт, үүрэн телефоны сүлжээ ашиглан эрхэлж байгаа хувь

хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд сар тутам 36250000 төгрөгтэй тэнцэх хэмжээгээр онцгой албан татвар ногдуулахаар зохицуулалттай хэдий ч дээрх хуулийн зохицуулалтын хүрээнд улсын төсөвт ямар нэгэн татвар төлөгдөөгүй байна.

Одоогийн нөхцөл байдал, авч хэрэгжуулж байгаа арга хэмжээ:

Үндэсний статистикийн хорооноос хийсэн судалгаагаар 2023 оны байдлаар эдийн засгийн гэмт хэрэг 200 бүртгэгдэж, 2024 онд эдийн засгийн гэмт хэргийн улмаас нийт 417.2 тэрбум төгрөгийн хохирол учирч, эдийн засгийн гэмт хэргийн хохирогчийн 9.2 хувийг 18-29 насны бүлэг, 47.7 хувийг 30-39 насны бүлэг, 24.6 хувийг 40-49 насны бүлэг эзэлж байна. Мөрдөн шалгах ажиллагааны явцад 240.9 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 23.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт цахим болон цахим бус хэлбэрээр хууль бусаар мөрийтэй болон бооцоот тоглоомын үйл ажиллагаа явуулах замаар мөнгө угаах, бусдыг залилах, татвар төлөхөөс зайлсхийх зэргээр эдийн засгийн гэмт хэргүүд ихээр үйлдэгдэж, сүүлийн 3 жилийн хугацаанд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.17 дугаар зүйлд заасан Мөрийтэй тоглоом зохион байгуулах зүйл ангиар 669 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж 200 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай явуулж, 104 хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн байна. Монгол улсад давхардсан тоогоор сүүлийн 3 жилийн хугацаанд хууль бус мөрийтэй тоглоомын 350-450 орчим сайт үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж байна.

Цахимаар мөрийтэй тоглоом болон бусад төрлийн бооцоот тоглоом эрхэлдэг гадаадын хуулийн этгээдийн үйл ажиллагаа Монгол Улсын хүн амын дунд түгээмэл болсон байгаа нь зайлшгүй шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудал болоод байна. Цагдаагийн байгууллагаас цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн дуудлага, мэдээлэлд хойшилуулшгүй ажиллагаа явуулж, арилжааны банкуудтай хамтран 2024 онд бусдад учирсан 7,3 тэрбум төгрөгийн хохиролтой 1,318 дуудлага, мэдээлэлд нийт мөнгөн дүнгийн 71,2 хувь буюу 5,2 тэрбум төгрөгийн дансны гүйлгээний шилжилт хөдөлгөөнд хязгаарлалт тогтоож, 120 иргэний 2,1 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, болзошгүй эрсдэлээс хамгаалсан.

Харин учирсан нийт хохирлын 28,8 хувь буюу 2,1 тэрбум төгрөгийн хохиролтой 565 дуудлага, мэдээлэлд хязгаарлалт тогтоогоогүй бөгөөд үүний үндсэн

шалтгаан нь 18,2 хувь буюу 103 иргэнээс хугацаа алдаж дуудлага ирүүлсэн, 47,9 хувь буюу 271 сэжигтэй этгээд ATM /бэлэн мөнгөний машин/ ашиглан бэлнээр авсан, 33,8 хувь буюу 191 сэжигтэй этгээд арилжааны хэд хэдэн банкны данс шилжүүлэн Binance, 1XBET зэрэгт мөнгөн гүйлгээ хийх замаар мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдсэнийг шалгаж байна.

Хэрэг бүртгэлтийн чиглэлээр “Хар мөрий” хэсэгчилсэн арга хэмжээг 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн зохион явуулж улсын хэмжээнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.17 дугаар зүйлд зааснаар хэсэгчилсэн арга хэмжээний үр дүнд хэрэг бүртгэлтийн 19 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татаж, хэрэг бүртгэлтийн 135 хэргийг хааж, 8 хэргийг нэгтгэж 3 болгон нэгтгэж, мөрдөн байцаалтын 21 хэргийг шүүхэд шилжүүлж, одоо хэрэг бүртгэлтийн 307, мөрдөн байцаалтын 18 хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлэн явуулж байна.

Хэрэг бүртгэлтийн 79 хэрэгт гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан арилжааны банкны 222 иргэний дансанд төвлөрсөн 3,4 тэрбум төгрөг, хууль бусаар олсон орлогоороо худалдан авсан байж болзошгүй 4,3 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий нуугдмал эд хөрөнгийг илрүүлж шилжилт хөдөлгөөнд прокурорын байгууллагын зөвшөөрлөөр хязгаарлалт тогтоож, мөнгөн дүнг зарцаасан хэргийн судалгааг гаргаж шийдвэрлүүлэх чиглэлээр мэргэжил арга зүйн удирдлагаар ханганд ажиллаж байна.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн утга агуулгатай контентыг нийтэлсэн тохиолдолд эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлтээр хууль зөрчсөн цахим хуудасны домэйн нэрийг зөрчилтэй домэйн нэрийн жагсаалтад [/black-list.mn/](http://black-list.mn/) бүртгэж, үүрэн холбооны болон интернэтийн үйлчилгээ эрхлэгчидтэй хамтран Монгол Улсын нутаг дэвсгэрээс хандах хандалтыг хязгаарлах технологийн арга хэмжээг 2012 оноос хойш авч хэрэгжүүлсэн. 2024 оны байдлаар гадаад, дотоодын 7192 орчим домэйн нэрийг зөрчилтэй домэйн нэрийн жагсаалтад бүртгэж хандалтыг хязгаарласан байна. Үүнд ихэвчлэн мөрийтэй тоглоом, оюуны өмчийн эрхийн зөрчилтэй, садар самуун, порнографыг сурталчилсан асуудалтай веб сайтуудын домэйн нэр бүртгэгдсэн байна. Жишээ нь, 2024 онд мөрийтэй тоглоомтой холбоотойгоор 454, оюуны өмчтэй холбоотойгоор 13, садар самуунтай холбоотойгоор 2, залилантай холбоотойгоор 2 зөрчилтэй домэйн нэр бүртгэгдсэн байна.

2012–2024 оны хооронд black-list.mn системд бүртгэгдсэн
зөрчилтэй цахим хуудас

Огноо	Цахим хуудасны тоо
2012	14
2013	44
2014	131
2015	168
2016	98
2017	118
2018	49
2019	60
2020	221
2021	474
2022	1138
2023	4206
2024	471
Нийт:	7192

Харилцаа холбооны зохицуулах хорооноос цахим хэлбэрээр үйлдэгдсэн хууль бус мөрийтэй тоглоомыг таслан зогсоох зорилгоор 2022-2024 онд Монгол улсын ерөнхий прокурорын газар, Монголбанк, Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн алба болон Харилцаа холбооны зохицуулах хорооны хамтарсан “Хяналт-1” болон “Хяналт-2” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан. Уг арга хэмжээний хүрээнд нийт цахимаар хууль бус мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа явуулсан 6036 домэйн хаягийн Монгол Улсаас хандах хандалтыг хязгаарласан байна.

Он	Тоо
2021	375
2022	1085
2023	4156
2024	454
НИЙТ:	6036

2024 онд цахим мөрийтэй тоглоомтой холбоотой цагдаагийн байгууллагаас ирүүлсэн албан бичгийн дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооноос хүсэлтийг META компанид хүргүүлж, дараах байдлаар шийдвэрлэж ажилласан байна:

№	Байгууллага	Зөрчил	Ирүүлсэн албан бичиг	Линк	Шийдвэрлэгдсэн	Хувь
1	Цагдаа	Мөрийтэй тоглоом /META/	276	2456	1876	76.38%

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.4 дэх заалтад заасан төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг “Темп партнерс” ХХК, “Эн Зэт Жи Эм” ХХК, “Мон Экс Бэй Ти Билэг” ХХК-д олгож, олон улсад бооцоот тоглоомын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 1XBET сайт нь одоогоор тусгай зөвшөөрөлгүй байна.

Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн мэдээллээр Монгол Улсын нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхэлж байгаа спортын бооцоот тоглоомын 1XBET сайтаар дамжуулан гэмт хэргийн замаар олсон хууль бус хөрөнгийг гүйвуулах, нуун далдлах, оффшор эргэлтэд оруулах, мөнгө угаах гол хэрэгсэл болж, бусдын эд хөрөнгийг залилах, хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээг далд байдлаар дэмжих, мөрийтэй тоглоом тоглох, авлига, албан тушаалын гэмт хэргийн замаар олсон мөнгийг угааж байгаа нөхцөл байдал тогтоогдсон.

Мөн мөрийтэй тоглоом тоглогчдод мөнгөн шилжүүлгийн үйлчилгээ үзүүлж, пирамид хэлбэрээр салбарлаж, бүлгийн зохион байгуулалттайгаар 1XBET-тэй гэрээ байгуулан цалин авч, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 110 гаруй “агент” байна гэсэн тоон мэдээ гарсан бөгөөд цагдаагийн байгууллагаас Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг үндэслэн Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албатай хамтран агентийн үйл ажиллагаа эрхэлдэг арилжааны банкууд дахь дансны гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг түдгэлзүүлэн шалгалтын ажиллагаа явуулсан байна. Энэ явцад их хэмжээний ашиг орлого олсон 11 агентад холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.3 дугаар зүйл (Татвар төлөхөөс зайлсхийх), 18.6 дугаар зүйл (Мөнгө угаах)-ийн хүрээнд 11 хэрэг

бүртгэлтийн хэрэг нээн Нийслэлийн прокурорын газрын хяналтанд мөрдөн шалгах ажиллагаа явуулж, Татварын ерөнхий газартай хамтран **112** агентад татварын хяналт шалгалт хийж ажиллахад **23** танилцуулга гарч, **24** акт тавьж, **65** агентад шалгалт хийгдэж байна.

Мөн Харилцаа холбооны зохицуулах хорооноос Монгол Улсын нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөлгүйгээр 1XBET гэх нэр, логог ашиглан төлбөрт таавар, бооцоот тоглоомын зар сурталчилгааг бүтээх, байрлуулах, түгээж буй аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаа нь Өрсөлдөөний тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай, Зар сурталчилгааны тухай болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт шалгалт хийж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газар, Монополын эсрэг газар болон Харилцаа холбооны зохицуулах хорооны хамтарсан “Хамтарсан хяналт шалгалт хийх тухай удирдамж”-г 2024 оны 10 сарын 20-ны өдөр баталсан. Энэхүү хяналт шалгалтыг 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс 45 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэж байна.

Монополын эсрэг газрын Улсын байцаагчийн дүгнэлт болон холбогдох эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэрийн дагуу 2018-2024 оны хооронд 1XBET-тэй холбоотой нийт 25 домэйн хаягийн Монгол Улсаас хандах хандалтыг хязгаарласан болно.

№	Домэйн нэр	Огноо
1	site-1xbetkz.com	2024.11.11
2	1xbetagent.shop	2024.11.11
3	1xbett.biz.ua	2024.11.11
4	1xbet-mn.com	2024.11.11
5	1xbet-mng.com	2024.11.11
6	1xbet-sport-mn.org	2024.11.11
7	1xbet-mongolia.com	2024.11.11
8	1xbet-stavki-mn.net	2024.11.11
9	1xbet-bonus-mng.com	2024.11.11
10	sport-1xbet-mng.com	2024.11.11
11	1xbet-registratsiya-mng.com	2024.11.11
12	1xbetmongolia.net	2024.11.11
13	ma-1xbet.com	2023.05.01

14	1xbet.com.gh	2023.05.01
15	1xbet.ng	2023.05.01
16	1xbet.mn	2023.01.19
17	1xbetmn.com	2021.11.03
18	1xbetmongolia.com	2021.10.18
19	1xbet-283599.top	2021.09.09
20	1xbet-459727.top	2021.09.09
21	1xbet.in	2021.09.07
22	1xbetmn6.com	2020.11.03
23	1xbetmn.mobi	2020.03.31
24	1xbet.mobi	2018.04.04
25	1xbet.com	2018.03.30

Монополын эсрэг газраас цагдаагийн байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран Монгол Улсын нутаг дэвсгэрт төлбөрт таавар, бооцоот тоглоомын зар сурталчилгааг бүтээж, түгээж байгаа этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, Зар сурталчилгааны тухай хуулийн 6.5.1-д “зөвшөөрөл аваагүй тохиолдолд тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааны талаар аливаа зар сурталчилгаа явуулахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн нэр бүхий 2 аж ахуй нэгж, 7 контент бүтээгчийн зөрчлийн шинжтэй үйлдэлд Зөрчлийн тухай хуулийн 10.1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтад заасны дагуу нийт 13.500.000 төгрөгийн тортгууль ногдуулсан.

Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны явцад Арабын Нэгдсэн Эмират, Хонг Конг зэрэг улсуудад бүртгэлтэй хуулийн этгээдээр дамжуулан Монгол улсад бүртгэлтэй нэр бүхий аж ахуй нэгжтэй 6.000-77.000 доллар хуртэлх гэрээ байгуулж спортын бооцоот тоглоомын 1XBET-ээс манай улсруу зар сурталчилгааны зорилгоор 3,345,468,075 төгрөг буюу 976,779 ам.доллар шилжүүлсэн боловч манай улсаас 1.7 их наяд төгрөг буюу 500 сая ам.доллар агентуудаар дамжин гадагш гарсан байна. Энэ нь гадаад улсын вэбсайтуудаар Монгол Улсын иргэд цахим гэмт хэрэг, залилангийн хохирогч болж, хөрөнгөө их хэмжээгээр алдах эрсдэлийг дагуулж, үндэсний валют хяналтгүйгээр гадагш урсаж, манай улсын эдийн засагт ихээхэн хохирол учруулж байгаа тул эдийн засгийн аюулгүй байдлыг хангах шаардлагатай байна.

Олон улсын туршлага:

Роберт Карсон, Жеймс Бутчер нар 1988 онд "Abnormal Psychology and Modern Life" номд мөрийтэй тоглоомыг тодорхой тоглоом эсвэл үйл явдал дээр бооцоо тавьж, их хэмжээний ашиг олохыг найдах үйл явц хэмээн тодорхойлсон байдаг (Khansa нар, 2022). Олон улсад бооцоот /мөрийтэй/ тоглоом гэдэг ойлголт нь: Бооцоо тавих (мөн "бооцоо тавих" гэж нэрлэдэг) нь ерөнхийдөө тодорхой бус үйл явдлын үр дүнд өөр үзэл бодолтой байгаа хэн нэгний эсрэг мөнгө, эсхүл материаллаг үнэ цэнтэй зүйл тавих гэж хууль ёсоор тодорхойлогддог (Blakey, 1984; Cabot, 1999; Lipton, Lazarus, & Weber, 2005; Rose, Vereu, & Weber, 2005; Rose, Verleu, 019).

Бооцоот тоглоомыг цахим бооцоот/мөрийтэй тоглоом (Online gambling), уламжлалт бооцоот/мөрийтэй тоглоом (offline gambling) гэж ерөнхийд нь ангилдаг байна. Гол ойлголтууд, чухал нэр томъёонуудыг Их Британи улсын Мөрийтэй тоглоомын тухай хууль (The Gambling Act 2005)-нд дараах байдлаар тайлбарласан байна:

1.Тоглоом (Gaming) - Шагналын төлөө азын тоглоом тоглохыг хэлнэ. Азын тоглоомд цэвэр аз турсан тоглоом төдийгүй ур чадварын элемент багтсан тоглоомууд ч орж болно. Үүнд: покер, рүлээт гм тоглоом орно. Харин спортын үйл ажиллагаа мөрийтэй тоглоомын ангилалд орохгүй.

2.Бооцоо (betting) - Ямар нэгэн үйл явдал, тэмцээн эсвэл тодорхойгүй үр дүн дээр бооцоо тавих. Үүнд спортын бооцоо, морины уралдааны бооцоо, бусад бооцоот тоглоомууд хамаарна.

3.Сугалаа (lottery) - Оролцогчид төлбөр төлж оролцох шаардлагатай шагналыг зөвхөн азаар хуваарилдаг. Шагнал нь мөнгө, эд зүйлс, эсхүл үйлчилгээ байж болдог.

4.Цахим бооцоот/мөрийтэй/ тоглоом: Интернэт, утас, телевиз, радио болон бусад технологийг ашиглан мөрийтэй тоглоомд оролцохыг хэлнэ гэж тодорхойлсон байна.

Цахим мөрийтэй тоглоом гэдэгт интернэтэд сууринсан буюу компьютер, гар утас, таб гэх мэт ямар ч төхөөрөмжийн интернэт холболт ашиглан тоглож болох мөрийтэй тоглоомуудыг хамруулж ойлгож болно. Цахим мөрийтэй тоглоомын тоглогчид нь дансандаа мөнгө байршуулж, байршуулсан мөнгөө ашиглан тоглох болон бооцоо тавих замаар оролцдог. Сүүлийн жилүүдэд цахим мөрийтэй

тоглоомын салбар нь блокчейн технологийг нэвтрүүлж, криптовалют ашиглан мөрийтэй тоглоомын гүйлгээ хийх явдал газар аваад байна. Криптовалютын гүйлгээнд тавигдах хязгаарлалт багатай, гүйлгээ хийхэд хурдан, хялбар байгаа зэрэг шинж чанараас хамаарч хэрэглэгчид цахим мөрийтэй тоглоомын төлбөр тооцоог криптовалютаар хийх хандлага их болж байна.

Data40.com байгууллагаас хийсэн судалгаагаар (www.data40.com) гадаад улс орнуудын цахим мөрийтэй болон бооцоот тоглоомыг хүлээн зөвшөөрч байгаа эсэх талаар 2024 оны 09 дүгээр сард гаргасан жагсаалтад манай улстай нийгмийн үнэлэмж, соёл, уламжлалын хувьд ижил төсөөтэй Ази-Номхон далайн бус нутгийн улс орнуудыг судалж үзэхэд, нийт 46 улс орны 21 улс нь цахим мөрийтэй болон бооцоот тоглоомыг хууль бус гэж тооцож, 7 улс хуулиар хүлээн зөвшөөрч, 6 улс хэсэгчилсэн байдлаар зохицуулж, 13 улс одоогоор зохицуулалтгүй байна. Хууль бус гэж тооцсон улс орны тоонд Япон, БНСУ, БНХАУ, Тайланд (морин уралдаанаас бусад), Вьетнам, Индонез, Малдив, Непал, Лаос, Бангладеш зэрэг улс орнууд байна. Сингапур Улсын хувьд 1968 онд оршин суугчдад лоттерей, спортын бооцоот тоглоом тоглох боломжийг олгох зорилгоор Төрийн өмчит хонжворт сугалааны компанийг байгуулсан ба 2008 онд тоглогчдын эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагаа эрхлэгчдэд хяналт тавих Казиногийн зохицуулалтын байгууллагыг байгуулж, 2014 онд Зайнаас тоглох мөрийтэй болон бооцоот тоглоомын тухай хуулийг баталж, цахим мөрийтэй тоглоомын ихэнх хэлбэрийг хориглосон.

Мөн мөрийтэй тоглоомын газар ажиллуулахыг хууль бус гэж тооцсон 18, хүлээн зөвшөөрсөн 15, хэсэгчилсэн 8, зохицуулалтгүй 4, зөвхөн засгийн газар нь зохицуулдаг 1 улс байна. Япон, БНСУ, Сингапур зэрэг улс орнууд уламжлалт мөрийтэй тоглоомын зарим хэлбэрийг хүлээн зөвшөөрдөг байна. Харин хуулиараа мөрийтэй болон бооцоот тоглоомыг хууль бус гэж тооцдог улсын орнуудын тоонд Индонез Улс ордог зэрэг олон улсын туршлагыг дурдаж болно.

Иймд өмнө дурдсан үндэслэл, шалтгаан, олон улсын туршлагыг харгалзан манай улсын эдийн засагт ихээхэн хэмжээний хохирол учруулж, эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байгаа үйлдлийг таслан зогсоох, хүүхэд, залуучуудын мөрийтэй болон бооцоот тоглоом тоглож, хөрөнгөө ихээр алдах, сэтгэл зүйн хувьд донтож эрүүл мэнд, амь насанд учрах эрсдэлээс сэргийлэх зорилгоор Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

хуулийн 33.1-д заасны дагуу боловсруулж, хуулийн төсөлд төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэхийг хориглож, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт заасны дагуу хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс олгодог төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагаанаас хасахаар тусгалаа.

Хуулийн төслийг дагаж Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхэлсэн, төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомд зуучилсан үйлдлийг гэмт хэрэгт тооцооор тусгалаа. Мөн төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэх гэмт хэргийг үйлдэж бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж, эсхүл зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан болно.

Түүнчлэн төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэхэд өөрийн нэр дээр бүртгэлтэй төлбөр тооцооны данс, цахим мөнгө, виртуал хөрөнгө, харилцаа холбооны сүлжээний дугаар, цахим хаягаа бусдад ашиглуулсан тохиолдолд Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэхээр нэмж тусгасан.

Мөн Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, төлбөрт таавар, бооцоот тоглоом, мөрийтэй тоглоомыг сурталчилж, уриалахыг хориглож, хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тусгалаа.

Мөрийтэй болон бооцоот тоглоомоос олсон хууль бус хөрөнгийг гүйвуулах, нуун далдлах, оффшор эргэлтэд оруулах, мөнгө угаах нөхцөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Банкны тухай хуульд нэмэлт оруулж, төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэх, зуучлах, төлбөрт таавар, бооцоот тоглоом, мөрийтэй тоглоом сурталчлах, эсхүл цахим хэрэгслийг ашигласан залилах гэмт хэрэгтэй тэмцэхэд шаардлагатай мэдээллийг хуульд заасны дагуу мөрдөн шалгах байгууллагаас шаардсан тохиолдолд гаргаж өгөх талаар тусгалаа.

Зөвшөөрлийн тухай хуульд төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоохоор заасантай холбогдуулан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Онцгой

албан татварын тухай, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

---ооо---

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 20 дахь хэсэг нэмсүгэй:

“20. Төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.”

2 дугаар зүйл. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг ... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай 20.18, 20.19 дүгээр зүйл нэмсүгэй:

“20.18 дугаар зүйл. Төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэх”

1. Олон нийтийн газар, эсхүл цахим сүлжээ ашиглан төлбөрт таавар, эсхүл бооцоот тоглоом, эсхүл цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагааг ашиг олох зорилгоор эрхэлсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ зүйлийн 1-д заасан гэмт хэргийг:

2.1. бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж;

2.2. зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ зүйлийн 1, 2-т заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Тайлбар:

- Энэ зүйлд заасан “Төлбөрт таавар” гэж бодит баримт, нотолгоонд үндэслэхгүйгээр, ирээдүйд бий болох тодорхой үр дүнг хийсвэрлэн төсөөлж төлбөр төлж оролцдог тааврыг;

- Энэ зүйлд заасан “Бооцоот тоглоом” гэж мэдлэг, туршлага, статистик мэдээлэлд үндэслэн магадлалыг урьдчилан тооцоолж, үр дүнг таамаглах боломжтой тоглоомыг;

- Энэ зүйлд заасан “Цахим мөрийтэй тоглоом” гэж цахим сүлжээ ашиглан үр дүнт нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог тоглоомыг.”

20.19 дүгээр зүйл.Төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомд зуучлах

1.Төлбөрт таавар, эсхүл бооцоот тоглоом, эсхүл цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэхэд өөрийн нэр дээр бүртгэлтэй төлбөр тооцооны данс, эсхүл цахим мөнгө, эсхүл виртуал хөрөнгө, эсхүл харилцаа холбооны сүлжээний дугаар, эсхүл цахим хаягаа бусдад ашиглуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Төлбөрт таавар, эсхүл бооцоот тоглоом, эсхүл цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэхэд зуучилсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн 10.1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

“6. Төлбөрт таавар, эсхүл бооцоот тоглоом, эсхүл мөрийтэй тоглоомыг сурталчилсан, уриалсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг таван мянган нэгж, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7. Төлбөрт таавар, эсхүл бооцоот тоглоом, эсхүл мөрийтэй тоглоомыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, эсхүл цахим сүлжээ ашиглаж сурталчилсан, уриалсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг арван мянган нэгж, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зар сурталчилгааны тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.2.4 дэх заалт нэмсүгэй:

“7.2.4.төлбөрт таавар, эсхүл бооцоот тоглоом, эсхүл мөрийтэй тоглоомыг сурталчилсан, уриалсан.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.2.12 дахь заалт нэмсүгэй:

“7.2.12. төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэх, зуучлах, төлбөрт таавар, бооцоот тоглоом, мөрийтэй тоглоом сурталчлах, цахим хэрэгслийг ашигласан залиах гэмт хэрэгт хуульд заасны дагуу мөрдөн шалгах байгууллагаас шаардсан.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Онцгой албан татварын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “бараа, түүнчлэн төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тусгай зориулалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж болон энэхүү үйл ажиллагааг эрхлэн явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдэд” гэснийг “бараанд” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Онцгой албан татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “, түүнчлэн төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхэлж байгаа” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл.Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 5 дугаар зүйлийн 5.4, 6 дугаар зүйлийн 6.4, 6.5, 8 дугаар зүйлийн 8.8, 8.9, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтын “төлбөрт таавар, бооцоот тоглоом,” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 11 дүгээр зүйлийн 11.1.2, 18 дугаар зүйлийн 18.6.5 дахь заалтын “төлбөрт таавар, бооцоот тоглоом,” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дэх заалтын “төлбөрт таавар, бооцоот тоглоом,” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

Гарын үсэг

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ЕӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ БОЛОН УГ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН
БОЛОВСРУУЛСАН БУСАД ХУУЛИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬЁГ

Д/Д	Байгууллагын нэр	Ирүүлсэн санал	Тайлбар
1.	Монголбанк 2025.03.13-А-1/204	<p>Таны 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн ХЭГ/581 Дүгээр албан бичгээр ирүүлсэн Зөвшүүрлийн тухай хуульд нэмэлт, еөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуулийн төсөлд санал авах тухай албан бичигтэй танилцлаа. Хууль сахиулах байгууллагаас хууль бус спорт таавар, мөрийтэй тоглоомын төрлийн хууль бус үйл ажиллагааг мөрдөн шалгах, таслан зогсооход харилцагчийн мэдээллийг түргэн шурхай гаргуулан авах, дансыг царцаах зэрэг арга хэмжээг авахад хуульд заасны дагуу Прокурорын зөвшөөрлийг авах нь энэ төрлийн гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхэд хундрэл үүсгэж, цаг алдах голлох хүчин зүйлс болж байгаа талаар дурддаг. Нэгэеэтэйгүүр, Банкны тухай хуулийн зохицуулалт нь харилцагчийн эмзэг, нууц мэдээллийг хамгаалах, зөвхөн хуульд заасан зорилгоор мэдээллийг гаргаж өгех, болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилготой байдаг. Эрүүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар мөрдөгч хойшлуулшигийг тохиолдолд энэ хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан мөрдөн шалгах ажиллагааг прокурорын зөвшөөрөлгүй явуулж болох зохицуулалттай. Иймд Банкны тухай хуульд оруулах еөрчлөлтийг дээрх төрлийн гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, бууруулах зорилгод нийцүүлэн илүү тодорхой болгох хүрээнд дараах байдаар уг хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3 дахь хэсгийг еөрчлөн найруулах саналтай байна:</p> <p>“7.2.3.шүүх, прокурорын байгууллагын удирдлага хүсэлт гаргасан, эсхүүл цагдаагийн байгууллага цахим запилах болон мөрийтэй</p>	

	<p>тоглоом, төлбөрт таавар, бооцоот таавар зохион байгуулах гэмт хэргийг мөрдөн шалгах хойшлуулшигүй ажиллагааны хурээнд шаардсан, эсхүл авлигатай тэмцэх байгууллага, цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаа, тагнуулын байгууллага мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон мэдээллийг шалгах шаардлагаар мөрдөгчийн саналыг прокурор зөвшөөрсөн.”</p>

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-11) 31 03 92, Факс: (976-11) 31 14 71,
Цахим хуудас: www.mongolbank.mn

2025. 03. 13 № A-1/204
таний -ны № -т

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Г Хуулийн төсөлд санал өгөх тухай

Таны 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн ХЭГ/581 дүгээр албан бичгээр ирүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуулийн төсөлд санал авах тухай албан бичигтэй танилцлаа.

Хууль сахиулах байгууллагаас хууль бус спорт таавар, мөрийтэй тоглоомын төрлийн хууль бус үйл ажиллагааг мөрдөн шалгах, таслан зогсооход харилцагчийг мэдээллийн түргэн шуурхай гаргуулан авах, дансыг царцаах зэрэг арга хэмжээг авахад хуульд заасны дагуу Прокурорын зөвшөөрлийг авах нь энэ төрлийн гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхэд хүндэрл үүсгэж, цаг алдах голлох хүчин зүйлс болж байгаа талаар дурддаг. Нөгөөтээгүүр, Банкны тухай хуулийн зохицуулалт нь харилцагчийн эмзэг, нууц мэдээллийг хамгаалах, зөвхөн хуульд заасан зорилгоор мэдээллийг гаргаж өгөх, болзошгүй эрсдэлээс хамгаалах, зорилготой байдаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар мөрдөгч хойшлуулшгүй тохиолдолд энэ хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан мөрдөн шалгах ажиллагааг прокурорын зөвшөөрөлгүй явуулж болох зохицуулалттай.

Иймд Банкны тухай хуульд оруулах өөрчлөлтийг дээрх төрлийн гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, бууруулах зорилгод нийцүүлэн илүү тодорхой болгох хүрээнд дараах байдлаар уг хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3 дахь хэсгийг өөрчлөн найруулах саналтай байна.

“7.2.3.шүүх, прокурорын байгууллагын удирдлага хүсэлт гаргасан, эсхүл цагдаагийн байгууллага цахим залилах болон мөрийтэй тоглоом, төлбөрт таавар, бооцоот таавар зохион байгуулах гэмт хэргийг мөрдөн шалгах хойшлуулшгүй ажиллагааны хүрээнд шаардсан, эсхүл авлигатай тэмцэх байгууллага, цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаа, тагнуулын байгууллага мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон мэдээллийг шалгах шаардлагаар мөрдөгчийн саналыг прокурор зөвшөөрсөн”

Хүндэтгэсэн

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

1525020709

**ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ БОЛОН УГ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН БОЛОВСРУУЛСАН
БУСАД ХУУЛИЙН ТӨСӨЛ**

АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

Д/д	Нэр	Албан тушаал
1.	Н.Учрал	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
2.	Б.Батцэцэг	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга
3.	Д.Саруул	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
4.	Х.Сүрэнхорол	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын Засгийн газрын ахлах референт
5.	Б.Золбоо	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын референт
6.	Г.Энхтайван	Монголбанкны дэд ерөнхийлөгч
7.	Н.Жамъянхүү	Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга
8.	Т.Сүхболд	Цагдаагийн ерөнхий газрын дарга
9.	С.Тайван	Цагдаагийн ерөнхий газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга
10.	Б.Батзориг	Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга
11.	Б.Билгүүн	Монополын эсрэг газрын дарга
12.	Г.Чинзориг	Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга
13.	А.Лувсан-очир	Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга
14.	Т.Батболд	Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын газрын дарга
15.	С.Гантулга	Дотоод хэргийн их сургуулийн ЭШНХ-ийн захирал, доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн хурандаа
16.	Л.Бат-Очир	Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн профессор, доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн дэд хурандаа